Tenger Capital



ГАДААДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ТОВЧ

2026.10.26-11.01

- Холбооны нөөцийн сан (Fed) 10 сарын 28-нд бодлогын хүүг 3.75-4.00 хувьд хэвээр үлдээлээ.
- Nasdaq 100 индекс долоо хоногт 1.98 хувиар буурав.
- Brent нефтийн үнэ баррель тутамд 117.64 ам.долларт хүрч, аравдугаар сард 13.6 хувиар өсчээ.

S&P 500	АНУ-ЫН БОНДЫН ӨГӨӨЖ, 10 ЖИЛ	BRENT, БАРРЕЛЬ ТУТАМД	АЛТ, УНЦ ТУТАМД
7'580.07 нэгж	**4.94**%	**117.64** ам.доллар	**3'875.20** ам.доллар
▼ -0.57%	▼ -0.06 нэгж хувь	▲ +0.79%	▼ -3.03%

Эх сурвалж: Reuters, АНУ-ын Сангийн яам, ICE, FMV Market Desk. Сууръ нь 10 сарын 23-ны хаалт, сүүлийн утга 10 сарын 30-ны хаалт.

10 сарын 29-нд Европын Төв банк хүүгээ 2.50 хувьд, 10 сарын 30-нд Японы Төв банк 1.25 орчим хувьд тус тус хэвээр үлдээсэн бол Канадын банк 10 сарын 28-нд 2.50 хувь болгон нэмэв.

Эх сурвалж: Европын Төв банк, Японы Төв банк, Канадын банк.

Тайлант долоо хоногийн индексүүд

Индекс	Хаалтын түвшин	Өөрчлөлт
KOSPI	5'730.74	▲ +3.25%
DAX	25'818.23	▲ +2.53%
Nikkei 225	63'290.11	▲ +0.95%
Hang Seng	23'294.42	▲ +0.87%
FTSE 100	10'729.78	▲ +0.37%
S&P 500	7'580.07	▼ -0.57%
Nasdaq 100	28'384.85	▼ -1.98%
Hang Seng TECH	3'754.90	▼ -3.02%

Эх сурвалж: Reuters, Nasdaq, AP. Сууръ нь 10 сарын 23-ны, сүүлийн утга 10 сарын 30-ны хаалт. Hang Seng таван өдөр арилжаалагдав.

Долоо хоногт тайлагнасан томоохон компаниудын улирлын үзүүлэлт

Компани	Огноо	Орлого, сая ам.доллар	Ашиг хүлээлтээс	Нэгж хувьцаанд, ам.доллар	Дараагийн хаалт
Microsoft	10.28	92'279	давав (Bloomberg)	4.92	▼ -0.16%
Alphabet	10.28	127'577	хүрсэнгүй (LSEG)	2.12	▼ -12.64%
Amazon	10.29	201'944	хүрсэнгүй (S&P Global)	1.89	▼ -1.41%
Intel	10.29	16'513	давав (Zacks)	0.52	▼ -28.58%
Caterpillar	10.29	20'680	давав (LSEG)	7.20	▼ -9.25%

Эх сурвалж: компанийн тайлан, Reuters, Zacks. Хүлээлтийг нүдэнд нэрлэсэн байгууллага нийтэлсэн. Дараагийн хаалт нь тайлангийн дараах өдрийн эхний арилжаа.

Улирлын тайлангийн дүр зураг. FactSet-ийн 10 сарын 30-ны тоймоор S&P 500-ийн 60 хувь тайлагнаж, тэдгээрийн 82 хувь нь ашгийн хүлээлтээс давсан бөгөөд нийлмэл ашгийн өсөлт 30.2 хувь болов. Давсан хэмжээ нь 1.9 хувь буюу таван жилийн 7.5 хувийн дунджаас бага байна. Alphabet 2026 оны төлөвлөгөөг 195-205 тэрбум ам.доллар хэвээр үлдээсэн бол Microsoft 45.2 тэрбум зарцуулсан нь өөрийн 50 тэрбумын төлөвлөгөөнөөс доогуур байжээ.

Эх сурвалж: FactSet, Alphabet, Microsoft. Тэнгэр Капиталын төсөөлөл, зөвлөмж биш.

Холбооны нөөцийн сангийн хоёр гишүүн хүү нэмэхийг санал болгов



АНУ-ЫН ЗГ-ЫН БОНДЫН ӨГӨӨЖ, 2 ЖИЛ	БОДЛОГЫН ХҮҮ
4.56%	**3.75-4.00%**
▼ -0.13 нэгж хувь	

Эх сурвалж: АНУ-ын Сангийн яам, Холбооны нөөцийн сан. Өгөөжийн өөрчлөлтийг 10 сарын 23-ны хаалттай харьцуулав.

Бодлогын хүү хэвээр үлдэв: ХНС-ын нээлттэй зах зээлийн үйл ажиллагааны хороо 10 сарын 27-28-нд бодлогын хүүг 3.75-4.00 хувьд хэвээр үлдээлээ. Санал 10-2 болж, эсрэг санал өгсөн хоёр гишүүн хүүг 0.25 нэгж хувиар нэмэхийг дэмжив.

Эх сурвалж: Холбооны нөөцийн сан.

Эдийн засгийн өсөлт хүлээлтээс дээгүүр гарав: Хорооны мэдэгдэлд эдийн засаг хүчтэй тэлж, инфляц өндөр хэвээр байгааг тэмдэглэжээ. 10 сарын 29-нд гуравдугаар улирлын ДНБ жилийн 3.4 хувиар өссөн нь 3.0 орчим хувийн хүлээлтээс дээгүүр байв.

Эх сурвалж: Холбооны нөөцийн сан, АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчоо.



Эх сурвалж: АНУ-ын Сангийн яам.

Өгөөж буурч, зөрүү тэлэв: АНУ-ын 2 жил ба 10 жилийн бондын өгөөж 13 ба 6 суурь нэгжээр тус тус буурлаа.

Эх сурвалж: АНУ-ын Сангийн яам.


Суурь мэдээлэл. ХНС-ын ерөнхийлөгч Кевин Уорш ирэх оноос эхлэн жил бүр болдог ээлжит 8 удаагийн хуралдааны нэгийг нь бодлогын хүүгийн санал хураалтгүйгээр зөвхөн дунд, урт хугацааны эдийн засгийн стратеги болон бүтэц, төлөвлөлтийн асуудалд тулгуурлан шийдвэр гаргаж байхаар болсоноо танилцууллаа.

Эх сурвалж: Холбооны нөөцийн сан, Conference Board.

Хүүгийн талаарх зах зээлийн хүлээлт: CME FedWatch-ийн тооцоогоор арванхоёрдугаар сард хүү нэмэх магадлал долоо хоногийн эцэст 70.7 хувь болж, өмнөх 76 орчим хувиас буурлаа.

Эх сурвалж: CME FedWatch.

Нефтийн үнэ 0.79 хувиар өсч, үнэт металл 8.88 хувь хүртэл буурав



BRENT, БАРРЕЛЬ ТУТАМД	МӨНГӨ, УНЦ ТУТАМД
117.64 ам.доллар	**49.13** ам.доллар
▲ +0.79%	▼ -8.88%

Эх сурвалж: ICE, FMV Market Desk. Сууръ нь 10 сарын 23-ны хаалт.


Нефтийн үнэ өсч, металлын үнэ буурав: Brent 10 сарын 30-нд баррель тутамд 117.64, WTI 104.12 ам.долларoop хаагдав. Харин алт 3.03, мөнгө 8.88, платин 7.61 хувиар тус тус уналаа.

Эх сурвалж: ICE, NYMEX (Reuters), FMV Market Desk.

Танкер луу довтолгоо хийх нь ихсэв: Их Британийн Тэнгисийн худалдааны ажиллагааны нэгдсэн төв (UKMTO) аравдугаар сард дөчин гурван дайралт бүртгэснээс гуч нь газрын тосны танкерт чиглэсэн довтолгоо байжээ. Мөн Оманы эргийн ойролцоо дөрвөн худалдааны танкер минд өртжээ.

Эх сурвалж: UKMTO, Reuters.

Нефть, үнэт металлын долоо хоногийн өөрчлөлт, хувь



Эх сурвалж: ICE, NYMEX (Reuters), FMV Market Desk. Сууръ нь 10 сарын 23-ны хаалт.

Дөрөв дэх сар өсөлт үргэлжлэв: Аравдугаар сард Brent 13.6, WTI 15.2 хувиар тус тус өсч, дөрөв дэх сар дараалан ханш өслөө.

Эх сурвалж: Reuters, FMV Market Desk.

Сууръ мэдээлэл. АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн газрын 10 сарын 28-ны тайлангаар түүхий нефтийн нөөц 1.9 сая баррелиар буурч 410.6 сая баррель болов.

Эх сурвалж: АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн газар (Reuters).

ОПЕК+-ийн олборлолтын шийдвэр: ОПЕК+-ийн долоон орон 11 сарын 1-нд цахимаар хуралдаж, өдөрт 31 сая орчим баррелийн зорилтоо арванхоёрдугаар сард ч хэвээр үлдээхээр болов. Зорилт ийнхүү есдүгээр сараас хойш дөрөв дэх сардаа хэвээр үлдлээ. Гэвч гишүүн орнуудын дийлэнх нь дайны улмаас зорилтоосоо доогуур олборлосон хэвээр байна. Бүх 21 гишүүн 11 сарын 29-нд хуралдаж, ирэх оны олборлолтын зорилтыг тогтооно.

Эх сурвалж: ОПЕК+ (The National).

Anthropic компани IPO-ийн хүсэлтийн маягт нийтэд ил боллоо



ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ОРЛОГО	ЦЭВЭР АЛДАГДЛЫН МӨНГӨН БУС ХЭСЭГ
16'286 сая ам.доллар	**89.65**%

Эх сурвалж: Anthropic, PBC, Form S-1 (SEC EDGAR).


Бүртгэлийн маягт ил болов: Anthropic, PBC компани 10 сарын 26-нд Form S-1 бүртгэлийн маягтаа нийтэд ил болголоо. А ангиллын хувьцааг Nasdaq Global Select Market-д ANT тикертэйгээр бүртгүүлэхээр хүсэлт гаргасан ч үнийн муж, хувьцааны тоо, татах дүн нь одоогоор маягтад тусгагдаагүй байна.

Эх сурвалж: Anthropic, PBC, Form S-1 (SEC EDGAR).

Алдагдлын дийлэнх нь мөнгөн бус: Эхний хагас жилийн орлого 16'286 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеийн 1'163 саяас огцом өсчээ. Цэвэр алдагдал 80'748 сая ам.доллар гарсны 72'388 сая нь хөрвөх бонд, деривативын өрийн мөнгөн бус дахин үнэлгээний зөрүүнээс үүдсэн байв.

Эх сурвалж: Anthropic, PBC, Form S-1 (SEC EDGAR).

Anthropic-ийн эхний хагас жилийн орлого, сая ам.доллар



Эх сурвалж: Anthropic, PBC, Form S-1 (SEC EDGAR).

Андеррайтерын синдикат бүрдэв: Синдикатад хорин хоёр андеррайтер багтаж, Goldman Sachs, Morgan Stanley нар үйл ажиллагааг голчлон удирдана.

Эх сурвалж: Anthropic, PBC, Form S-1 (SEC EDGAR).

Суурь мэдээлэл. Маягтад хувьцааны таван ангилал тусгагдсан бөгөөд долоон үүсгэн байгуулагчийн компанид нийт саналын эрхийн 50.1 хувийг эзэмших F ангиллын хувьцааг гаргахаар заажээ. Мөн тус компанийн мөнгөн хөрөнгө болон богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 131.65 тэрбум ($131'651 сая) ам.долларт хүрсэн байна.